**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2025/038/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н:Баттогоо
Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn

Аудитор: Р.Баярмаа
Утас: 325093 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/190

танай ____________-ны № ____________-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА А.ДҮҮДЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд “Хүүхдийн сургуулийн автобус” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг тээвэрлэж байсан 16 автобусыг Зорчигч тээврийн баазуудад хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Харьяа ерөнхий боловсролын сургуулиудад Boom, Person edu, Eduten зэрэг англи хэлний төсөл, “Сүү” хөтөлбөр, “Койка” төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дүүргийн ЗДТГ-аас 206.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч сургалт, арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор байршуулаагүй, цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

02003682
C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.SHD.BH.docx

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.SHD.BH.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,684,095.34** | **5,350,451.00** |
| **33** | **АВЛАГА** | 76,001.02 | 76,001.02 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 17,025.51 |
| **335** | **Бусад авлага** | 76,001.02 | 58,975.51 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 76,001.02 | 58,975.51 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 98,608,094.32 | 5,274,449.98 |
| **354** | **Хангамжийн материал** | 98,608,094.32 | 5,274,449.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,394,560.00 | 40,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 87,500.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 190,000.00 | 190,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 92,936,034.32 | 5,044,449.98 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **58,653,649.54** | **75,505,457.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 58,653,649.54 | 75,505,457.74 |
| **392** | **Биет хөрөнгө** | 58,653,649.54 | 75,505,457.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 68,240,384.40 | 87,055,545.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (23,353,819.23) | (26,459,788.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,580,318.00 | 22,058,298.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,813,233.63) | (7,148,596.42) |
| 39301 | Програм хангамж | 935,000.00 | 935,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (935,000.00) | (935,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **157,337,744.88** | **80,855,908.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **157,337,744.88** | **80,855,908.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 157,337,744.88 | 80,855,908.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 13,303,419.32 | 13,303,419.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 13,303,419.32 | 13,303,419.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 144,034,325.56 | 67,552,489.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 122,123,756.53 | 144,034,325.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 21,910,569.03 | (76,481,836.14) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **157,337,744.88** | **80,855,908.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **674,038,199.80** | **3,066,982,045.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **355,111,625.56** | **2,559,920,245.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 355,111,625.56 | 2,559,920,245.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 3,289,659.56 | 31,534,245.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 351,821,966.00 | 2,528,386,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **318,926,574.24** | **507,061,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 279,326,300.00 | 300,401,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 278,506,574.24 | 300,401,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,420,000.00 | 206,660,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,332,500.00 | 206,660,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 87,500.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **652,127,630.77** | **523,188,740.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **652,127,630.77** | **523,188,740.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 652,127,630.77 | 509,678,538.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,689,073.22 | 240,461,635.67 |
| 210101 | Үндсэн цалин | 127,203,314.73 | 128,963,457.88 |
| 210102 | Нэмэгдэл | 51,867,227.70 | 35,032,841.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,220,500.00 | 34,863,951.36 |
| 210104 | Урамшуулал | 14,398,030.79 | 16,782,890.62 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 24,818,494.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,181,700.00 | 29,288,362.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,826,900.00 | 19,829,840.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,088,700.00 | 2,291,423.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,671,000.00 | 1,254,240.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 417,700.00 | 1,145,711.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,177,400.00 | 4,767,146.49 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 356,222,002.42 | 9,654,160.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,086,740.00 | 8,241,060.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 280,500.00 | 246,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 336,600.00 | 448,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 348,191,966.02 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 221,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 496,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,326,196.40 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50,034,855.13 | 230,274,380.49 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,832,500.00 | 186,315,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,098,500.00 | 21,612,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,103,855.13 | 22,347,380.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 13,510,201.88 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 6,950,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 5,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 6,560,201.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 819,725.76 | 6,560,201.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **21,910,569.03** | **2,543,793,304.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 2,620,275,140.65 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 3,032,556.31 |
| 210409 | Бараа материал шилжүүлсэн зардал | - | 2,617,242,584.34 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (2,620,275,140.65) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **21,910,569.03** | **(76,481,836.14)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **318,926,574.24** | **507,061,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **318,926,574.24** | **507,061,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 278,506,574.24 | 300,401,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 278,506,574.24 | 300,401,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,420,000.00 | 206,660,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,332,500.00 | 206,660,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 87,500.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА бa ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **296,736,674.24** | **496,364,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **296,736,674.24** | **496,364,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **296,736,674.24** | **482,854,098.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,765,074.24 | 240,461,635.67 |
| 210101 | Үндсэн цалин | 127,279,315.75 | 128,963,457.88 |
| 210102 | Нэмэгдэл | 51,867,227.70 | 35,032,841.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,220,500.00 | 34,863,951.36 |
| 210104 | Урамшуулал | 14,398,030.79 | 16,782,890.62 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 24,818,494.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,181,700.00 | 29,288,362.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,826,900.00 | 19,634,559.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,088,700.00 | 2,268,989.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,671,000.00 | 1,243,024.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 417,700.00 | 1,134,495.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,177,400.00 | 5,007,293.44 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,161,400.00 | 3,659,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,586,500.00 | 1,555,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 190,000.00 | 190,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 336,600.00 | 504,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,048,300.00 | 1,409,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 60,000.00 | 770,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 60,000.00 | 770,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,568,500.00 | 208,674,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,420,000.00 | 185,931,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,148,500.00 | 22,743,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **13,510,201.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 6,950,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 5,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 6,560,201.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **22,189,900.00** | **10,697,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **22,189,900.00** | **10,697,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,189,900.00** | **10,697,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 22,189,900.00 | 10,697,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,189,900.00 | 10,697,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(22,189,900.00)** | **(10,697,500.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 13,303,419.32 | - | 122,123,756.53 | **135,427,175.85** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **13,303,419.32** | **-** | **122,123,756.53** | **135,427,175.85** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 21,910,569.03 | 21,910,569.03 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,303,419.32** | **-** | **144,034,325.56** | **157,337,744.88** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **13,303,419.32** | **-** | **144,034,325.56** | **157,337,744.88** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **13,303,419.32** | **-** | **144,034,325.56** | **157,337,744.88** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (76,481,836.14) | (76,481,836.14) |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,303,419.32** | **-** | **67,552,489.42** | **80,855,908.74** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 300,401,800.00 | 293,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 300,401,800.00 | 293,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 295,401,800.00 | 288,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 245,597,100.00 | 240,461,635.67 | 5,135,464.33 | 97.9 |
| 210101 | Үндсэн цалин | 147,659,000.00 | 128,963,457.88 | 18,695,542.12 | 87.8 |
| 210102 | Нэмэгдэл | 40,683,800.00 | 35,032,841.71 | 5,650,958.29 | 86.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,514,300.00 | 34,863,951.36 | (2,349,651.36) | 107.2 |
| 210104 | Урамшуулал | 24,740,000.00 | 16,782,890.62 | 7,957,109.38 | 67.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 24,818,494.10 | (24,818,494.10) | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,699,700.00 | 29,288,362.45 | 1,411,337.55 | 95.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,875,800.00 | 19,634,559.59 | 1,241,240.41 | 94.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,456,000.00 | 2,268,989.80 | 187,010.20 | 92.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,228,000.00 | 1,243,024.21 | (15,024.21) | 101.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,228,000.00 | 1,134,495.41 | 93,504.59 | 92.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,911,900.00 | 5,007,293.44 | (95,393.44) | 101.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,273,000.00 | 4,259,600.00 | 13,400.00 | 99.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,556,600.00 | 1,555,000.00 | 1,600.00 | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 194,300.00 | 190,000.00 | 4,300.00 | 97.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 512,400.00 | 504,900.00 | 7,500.00 | 98.5 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - | - | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,009,700.00 | 2,009,700.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,208,000.00 | 2,208,000.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,208,000.00 | 2,208,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,624,000.00 | 12,624,000.00 | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,592,300.00 | 6,592,300.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,031,700.00 | 6,031,700.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 300,401,800.00 | 293,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 300,401,800.00 | 293,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 300,401,800.00 | 293,841,598.12 | 6,560,201.88 | 97.8 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 10.00 | 10.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **10.00** | **10.00** | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1.00 | 1.00 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.18695542,12*

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **206,660,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **206,660,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 204,710,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 204,710,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 185,060,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,650,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,950,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,950,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,950,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 206,660,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 206,660,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 206,660,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 483,295.0 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 7,384.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,925.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 5,459.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,384.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,658.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг дутуу тайлагнасан. | 1 | 6,560.2 | 1 | 6,560.2 | | | 1 | 6,560.2 | | | | |
| Сургуулиудад тараасан сурах бичгийг нөөцийн бараагаар бүртгэж тайлагнасан. | 1 | 467,637.8 | | | 1 | 467,637.8 | 1 | 467,637.8 | | | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд орлогод авч бүртгээгүй. | 1 | 9,097.0 | 1 | 9,097.0 | | | 1 | 9,097.0 | | | | |
| **Дүн** | **3** | **483,295.0** | **2** | **15,657.2** | 1 | **467,637.8** | **3** | **483,295.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг албан хаагчид анхан шатны баримтгүйгээр 473.2 мянган төгрөгийн цалинг илүү олгосон. | 1 | 473.2 | 1 | 473.2 | | | | | | | | |
| Нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал, балансын урамшууллаас гадна урамшуулал олгосон. | 1 | 1,452.0 | 1 | 1,452.0 | | | | | | | | |
| Акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгийг хүлээлгэн өгсөн болон устгаж акт үйлдээгүй, борлуулж төсөвт төвлөрүүлээгүй ,шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнаагүй. | 1 | 5,459.4 | | | | | 1 | 5,459.4 | | | | |
| **Дүн** | **3** | **7,384.6** | **2** | **1,925.2** | | | **1** | **5,459.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий 128,679.0 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 19,650.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 148,329.0 | | | 1 | 148,329.0 |
| Дүн | 1 | 148,329.0 | | | 1 | 148,329.0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| 3 мэргэжилтэнд 3,448.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл цалин олгосон. Төсвийн шууд захирагч нь батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа хүний ажлын ачаалал, амралтыг зохицуулж, зохион байгуулалт хийгээгүй байна. | 1 | 3,448.6 | | | 1 | 3,448.6 |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны | 1 | - | | | 1 | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй. | | | | | | |
| Цахим дэлгүүрээс бараа материалын худалдан авалт хийгээгүй байна. | 1 | 13,762.2 | | | 1 | 13,762.2 |
| Дүн | 3 | 17,210.8 | | | 3 | 17,210.8 |
| **Нийт дүн** | **4** | **165,539.8** | | | **4** | **165,539.8** |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 16/A0270227 Улаанбаатар хот

НТАГ-2025/038/НА-СТА-ТШЗ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд нэг албан хаагчид анхан шатны баримтгүйгээр 473,200.00 (дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун) төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д *“Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”* заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Анхан шатны баримтгүйгээр олгосон 473,200.00 (дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуу) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн дарга А.Дүүдээ, нягтлан бодогч Г.Болорчимэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:**

| | |
|---|---|
| АУДИТОР | Р.БАЯРМАА |
| ХЯНАСАН: | |
| САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР | Я.АЛТАНЦЭЦЭГ |

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051135

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 17/А0270227 Улаанбаатар хот

НТАГ-2025/038/НА-СТА-ТШЗ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Байгууллагын нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал, балансын урамшууллаас гадна оны эцэст үндсэн цалингаас 100 хувиар тооцож 1,452,000.00 (нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-д "*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "*Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Илүү олгосон урамшууллын 1,452,000.00 (нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн дарга А.Дүүдээ, нягтлан бодогч Г.Болорчимэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:**

| | | |
|---|---|---|
| АУДИТОР | | Р.БАЯРМАА |
| | ХЯНАСАН: | |
| САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР | | Я.АЛТАНЦЭЦЭГ |

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

0205113 6